

Ногдол ашиг тараах, хувьцаа эзэмшигчдэд
данс нээх ажлыг зохион байгуулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 17 дугаар тогтоолын нэгийн 4-т заасан үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2-т заасныг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Мөнгөн буюу хувьцаа хэлбэрээр хуваарилсан ногдол ашгийг компани дээрээ олгодог практикийг 2008 оноос эхлэн зогсоож, “ҮЦТТТХТ” ХХК-тай зуучлалын үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсны үндсэн дээр ногдол ашиг олгох ажлыг зохион байгуулж байхыг ХК-иудын удирдлагад үүрэг болгосугай.

2. Өмнөх жилүүдэд мөнгөн буюу хувьцааны хэлбэрээр хуваарилсан ногдол ашгийн тооцоог бүрэн гаргаж, үлдэгдлийг “ҮЦТТТХТ” ХХК-д хүлээлгэн өгөх арга хэмжээг 2008 оны 5 дугаар сард багтаан авахыг компани дээрээ ногдол ашгаа тараасан ХК-иудын удирдлагад, уг арга хэмжээний үр дүнг эхний хагас жилд багтаан Хороонд танилцуулахыг “ҮЦТТТХТ” ХХК-д үүрэг болгосугай.

3. Хэрэв хувьцаа эзэмшигч нь “ҮЦТТТХТ” ХХК-д дансаа нээлгээгүй бол түүнд хуваарилагдсан ногдол ашгаас нь данс нээлгэх хураамжийг суутган авч, үлдэгдлийг тухайн дансанд нь байршуулахыг “ҮЦТТТХТ” ХХК-д зөвшөөрсүгэй.

4. Тухайн хувьцаа эзэмшигчид хуваарилагдсан ногдол ашиг нь энэ тогтоолын 3-т зааснаар данс нээлгэх хураамжийг төлөхөд хүрэлцэхгүй бол шаардлагатай хөрөнгийг гаргах буюу эсвэл “ҮЦТТТХТ” ХХК-тай байгуулах гэрээгээр харилцан хөнгөлөлт үзүүлэх талаар тохиролцох зэргээр хувьцаа эзэмшигч бүртээ данс нээлгэх арга хэмжээ авахыг ХК-иудын удирдлагад үүрэг болгосугай.

5. Хувьцаа эзэмшигч бүртээ данс нээлгэхийг өмнөх жилүүдэд ногдол ашиг тараагаагүй бүх ХК-ийн удирдлагад үүрэг болгосугай.

6. Арилжаанд орох эрх нээгдсэн дансны эзний зөвшөөрөлгүйгээр гүйлгээ хийхгүй байхыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

7. Энэ тогтоолыг нийтэд сурталчлахыг Тамгын газар /Ж.Жадамбаа/, хэрэгжилтэд хяналт тавьж, дүнг 2008 оны 3 дугаар улиралд багтаан Хороонд танилцуулахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ